



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 17-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

### НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 6 дугаар бүлэг, 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар бүлгийн 8.13.16 дахь хэсэг, 11 дүгээр бүлэг болон 2025 оны 02 сарын 17-ны өдөр хуралдсан “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн 2024 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас 1,176,943,298.51 /Нэг тэрбум нэг зуун далан зургаан сая есөн зуун дөчин гурван мянга хоёр зуун ерэн найман төгрөг тавин нэгэн мөнгө/ төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохыг зөвшөөрсүгэй.
2. “Сүү” ХК-ийн нэгж хувьцаа тус бүрд 3.43 /Гурван төгрөг дөчин гурван мөнгө/ төгрөгийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр олгож, ногдол ашгийг тараах, түүнтэй холбоотой ажлыг зохион байгуулах, холбогдох баримт бичигт компанийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д олгосугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг “Сүү” ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
4. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд 2025 оны 05 сарын 30-ны өдөр тарааж дуусгасугай.
5. Энэхүү шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Д.ГАНБААТАР

